



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2019 оны 11 сарын 29 өдөр

Дугаар А/529

Улаанбаатар хот

Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд  
мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх  
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам”-ын 2.17 дах заалт, Монгол Улсын Засгийн газар, Люксембургийн Их Гүнт Улсын Засгийн газар хооронд 2017 оны 6 дугаар сард байгуулсан “Монгол Улсын Зүрх судасны үндэсний төв ба зүрх судасны тусламж үйлчилгээг уялдуулан сайжруулах нь МОН/006” төслийн гэрээ, Улсын гуравдугаар төв эмнэлэг, Бүгд Найрамдах Солонгос Улсын “Ча Бунданг” эрүүл мэндийн төв хооронд 2018 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр байгуулсан “Зөвлөх үйлчилгээний гэрээ”-г тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох 2 гадаадын эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг хавсралтаар баталсугай.
2. Зөвшөөрлийн гэрчилгээг баталгаажуулж олгохыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Нарантуяа/-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Б.Цогтбаатар/-д даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ



Эрүүл мэндийн сайдын  
2019 оны 11 сарын 14-ны өдрийн  
1529 дугаар тушаалын хавсралт

МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ  
ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ,  
ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

№	Овог нэр	Харьяалал	Монгол Улсад ажиллах байгууллага	Хамтран ажиллах гадаадын байгууллага	Гэрчилгээний сери/дугаар	Төрөлжсөн мэргэшлийн чиглэл	Зөвшөөрлийн төрөл	Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа
1.	Чан Бюл Чул Chang Buung Chul	Бүгд Найрамдах Солонгос Улс	Улсын гуравдугаар төв эмнэлэг	Бүгд Найрамдах Солонгос Улсын "Ча Бунданг" эрүүл мэндийн төв	ГЭ0002487	Цээжний ба зурх судасны мэс засал судлал	Эмчлэх	2019.12.01-2019.12.07 17 хоног/
2.	Пак Хан Ки Park Han Ki	Бүгд Найрамдах Солонгос Улс	Улсын гуравдугаар төв эмнэлэг	Бүгд Найрамдах Солонгос Улсын "Ча Бунданг" эрүүл мэндийн төв	ГЭ0002488	Цээжний ба зурх судасны мэс засал судлал	Эмчлэх	2019.12.01-2019.12.07 17 хоног/